



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/226

Улаанбаатар хот

ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг танилцуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ректорын ажлын албаны дарга (Н.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Геологи, уул уурхайн сургуулийн албан тушаал, орон тооноос ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн даргын албан тушаалын 1 орон тоог тус их сургуулийн захиргаанд шилжүүлж, ШУТИС-ийн захирлын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/233 дугаар тушаалаар баталсан ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

РЕКТОР




Т.НАМНАН

367040186



ШУТИС-ийн Ректорын 2024 оны 07 дугаар сарын
01-ний өдрийн 2 дугаар тушаалын хавсралт

| | | | |
|---|---|--------------------|------------|
|  | ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журам ШУТИС-ХН-ЖУО.. | Эхний хэвлэлт | 2018.11.30 |
| | | Өөрчилсөн огноо | 2024.07.01 |
| | | Өөрчлөлтийн дугаар | 2 |

ШУТИС-ИЙН АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Боловсруулсан:

РЕКТОРЫН АЖЛЫН АЛБА

АХМАДЫН ЗӨВЛӨЛ

Хянасан:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ийн РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн РЕКТОР



ШУТИС-ийн Ректорын Иргэний 07 дугаар сарын
01-ний өдрийн 01 дугаар тушаалын хавсралт

АГУУЛГА

| | |
|---|---|
| АГУУЛГА..... | 2 |
| НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ | 3 |
| ХОЁР. АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ..... | 3 |
| ГУРАВ. АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 4 |
| ДӨРӨВ. БУСАД..... | 4 |



ШУТИС-ийн Ректорын оны 07 дугаар сарын
01-ий өдрийн 07 дугаар тушаалын хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. ШУТИС-ийн ахмадын зөвлөл (цаашид “Ахмадын зөвлөл” гэх) нь тус их сургуульд ажиллаж байгаа тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн болон тус их сургуулиас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад багш, ажилтнуудын сайн дурын байгууллага мөн.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь Ахмад настны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, ШУТИС-ийн дүрэм, журам, Хамтын гэрээнд нийцүүлэн ШУТИС-ийн зорилго, зорилт, хууль ёсны эрх ашигт нийцсэн ахмад настны сайн дурын ажил хийхийг дэмжихэд оршино.
- 1.3. Ахмадын зөвлөл нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд өөрийн зорилгоо илэрхийлсэн, үйл ажиллагаанд хэрэглэгдэх албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

ХОЁР. АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Ахмадын зөвлөл нь ШУТИС-ийн захиргааны холбогдох нэгж (Ректорын ажлын алба)-д харьяалагдана.
- 2.2. Ахмадын зөвлөлийн хамтын удирдлага нь дарга, орлогч дарга, бүрэлдэхүүн, салбар сургуулийн Ахмадын салбар зөвлөлийн дарга, төлөөллөөс бүрдсэн сайн дурын 15 хүртэлх сондгой тооны тэргүүлэгчдээс бүрдэнэ.
- 2.3. Ахмадын зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг ШУТИС-ийн Ректорын тушаалаар томилогдсон Зөвлөлийн дарга удирдана.
- 2.4. Ахмадын зөвлөлийн дарга нь ШУТИС-ийн профессорын албан тушаалын цалингийн 50 хувиар цалинжин, ноогдол кредитийн ачаалалгүй ажиллана.
- 2.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Ахмадын салбар зөвлөлийн даргыг тухайн сургуулийн захирлын тушаалаар томилон, сар бүр 150,000 төгрөгийн хөлс олгоно.
- 2.6. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургуулийн ахмадын салбар зөвлөлийн дарга нараас 1 хүнийг сонгон, Ахмадын зөвлөлийн даргын саналыг үндэслэн Ахмадын зөвлөлийн орлогч даргаар томилон ажиллуулж болно.
- 2.7. ШУТИС-д ажиллаж байгаа тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн болон тус их сургуулиас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад багш, ажилтан бүр Ахмадын зөвлөлийн гишүүн байна.
- 2.8. Ахмадын зөвлөлийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг ШУТИС-ийн харьяалах захиргааны нэгжтэй зөвшилцөн боловсруулж, мөрдөн ажиллана.
- 2.9. Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг ШУТИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн тухайн оны төсөвт тусгуулан батлуулж, батлагдсан төсвийн дагуу зарцуулан захиргааны холбогдох албанд тайлагнана.



ШУТИС-ийн Ректорын Тамганы 07 дугаар сарын
07-ний өдрийн 07 дугаар тушаалын хавсралт

ГУРАВ. АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Ахмадын зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
 - 3.1.1. Их сургуулийн эрхэм зорилтыг хэрэгжүүлэхэд ШУТИС-ийн захиргаа, бүтцийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, Оюутны холбоо, Төгсөгч дэмжигчдийн байгууллага, Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.2. Монголын ахмад багш нарын холбооны үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө, үүсгэл санаачлагыг дэмжин ажиллах;
 - 3.1.3. Ахмад настны эрх ашгийг хамгаалан тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлж, ахмадуудын санал санаачлагыг дэмжин ажиллах;
 - 3.1.4. Ахмадын чөлөөт цаг, эрүүл мэндийн үйл ажиллагааг дэмжиж, урлаг, спортын тоглолт, аялалын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
 - 3.1.5. Ахмад туршлагатай эрдэмтэн багш, ажилтнаар сургалт явуулах, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгүүлэх;
 - 3.1.6. Багш, ажилтныг соён гэгээрүүлэх, ёс зүйн чиглэлийн сургалт, арга хэмжээг Ёс зүйн зөвлөлтэй хамтран зохион байгуулах;
 - 3.1.7. Цагаан сар, Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан мөн Нас тэгширсэн (эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас) ойгоор ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажиллагааг ШУТИС-ийн захиргаатай хамтран зохион байгуулах;
 - 3.1.8. Эмчилгээний дэмжлэг шаардагдах болон бусад гачигдал тохиолдоход ахмад настанд тэтгэмж, дэмжлэг авах асуудлыг ШУТИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн захиргаанд уламжлах;
 - 3.1.9. Ахмад настныг ШУТИС-ийн болон төрийн дээд одон, медаль, шагналд тодорхойлох, санал санаачлага гаргах;
 - 3.1.10. Ахмад настны ой, бусад тэмдэглэлт үйл явдлуудад талархал илэрхийлэх, сурталчлах ажлыг дэмжин хамтран оролцох;
 - 3.1.11. Ахмадуудын нэр, төр алдар гавьяаг дурсан тэмдэглэх, тэдэнд хүндэтгэл үзүүлэх, хөдөлмөрийн алдрыг түгээн дэлгэрүүлэх, тэдний эрдэм оюун, ур ухаан, ажлын ариун баялаг арга туршлагаас суралцуулах ажлыг санаачлан хэрэгжүүлэх;
 - 3.1.12. Бусад их сургууль, коллеж, боловсролын байгууллагатай хамтран ажиллах, туршлага санаачлагыг судлах;
 - 3.1.13. Бүх шатны ахмадын байгууллагуудтай хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1. Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг ШУТИС-ийн Веб сайтын Ахмадын зөвлөл цэсэнд тогтмол байршуулан танилцуулна.
- 4.2. Ахмадын зөвлөлийн гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг хичээлийн жил бүрийн төгсгөлд Ректорын зөвлөлд танилцуулан үнэлүүлнэ.